



Хууль, эрх зүй

"Хил судлал" сэтгүүлийн 2000 оны №4, 2001 оны №1-д
нийтлэгдсэн өгүүлэлүүдийн 3 дахь цуврал.

ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

"Дайн зөвхөн улс төрийн
бодлогын үргэлжлэл төдийгүй
гэмт явдлын үргэлжлэл байдаг"

Хельмут Мольтке

Хүн төрөлхтөн арьс өнгө, яс үндэс, хэл, соёл, шашин шүтлэгээрээ ялгаран хил хязгаарлалт тогтоон, бие биеэсээ тусгаарлан сууж басхүү зарим нэг цаг үед өөр хоорондоо алалдан тэмцэж ирсэн нь маргаангүйн адил агуу их буурал түүхийнхээ явцад аль нэгэн улс орон бүс нутаг юмуу энэ л ганцхан дэлхийн бүхий л ухаант хүмүүст гамшиг заналаа тулгаж байсан нь үнэн билээ. Ер нь дэлхий нийт дайны аюулыг зогсоон барих асуудлыг ямар нэг байдлаар шийдэж чадлаа гэхэд хүн төрөлхтөн түүний ардчилал, эдийн засгийн хөгжилд уламжлагдаж ирсэн эрүүгийн, эд хөрөнгийн, эдийн засгийн, генийн болон магадгүй төр, тусгаар тогтнолд заналхийх үндэсний ба үндэстэн хооронд дамжсан, эрчимтэй ахицдаа аль хэдийнээ орсон гэмт явдал хамгийн том аюул болно. Түүнтэй хийх тэмцэл хүн төрөлхтний туулсан дайнуудаас ч дутуугүй цус урсгасан ихээхэн сүйдэлтэй, онцгой байр суурьтай урт удаан хугацааны үйл явц байв. XX зууны сүүлийн 10 гаруй жилд гэмт-явдалтай тэмцэх олон улсын хамтын ажиллагааны явц үнэндээ сайтар өссөн юм. Энэ хамтын ажиллагааны хэмжээ, үндэс чиглэл, хэлбэр эд бүгд нь алив улс орны төр, дэлхий нийт амин хэрэгцээт энэ асуудлаа шийдэхэд эрүүгийн хууль зүйн хүрээнд хүчээ нэгтгэхийн чухлыг шаарддаг болно. Зохион байгуулалттай гэмт явдал улс үндэстэн хоорондын шинжтэй болсон өнөөгийн нөхцөлд түүнийг урьдчилан сэргийлэх, таслан зогсоох талаарх арга хэмжээний боловсруулалт, тохиролцсоныхоо дагуу хэрэгжиж чадах явдал сайн талын мэдэгдэхүйц үр дүнг буй болгодог. Интернациональжсан орчин үеийн нийгмийн амьдрал улс орнуудын хилийг "саадгүй" болгож, бараа таваар, санхүү-зээлийг өргөжүүлж, холбоо тээврийг хурдацтай хөгжүүлэн, хүмүүс хоорондын харилцаа, түүн дотор олон улсын хэмжээний далайцтай хууль бус үйл ажиллагаануудад ч аятай нөхцөлийг бүрдүүлж өгсөн. Нийтлэг энэ

аюулын өмнө хүн төрөлхтөн гар хумхиж удаан суугаагүй, бүр түрүүнээс тодорхой хэлбэл дэлхийн II дайны дараагаас бодитой хамтран тэмцэж эхэлсэн юм.

Тэр цагт үндэсний болон үндэстэн дамжсан гэмт хэргүүд мэдэгдэхүйц өсөж Хойд Америк мөн Европын бүс нутагт бүр дэлхий дахинаас криминологийн нөхцөл байдал ихэд төвөгтэй болж ирсэн нь түүний эсрэг хамтран ажиллах ажиллагааг зохицуулах байгууллагуудыг зүй ёсоор шаардаж байлаа. Энэ үүргийг НҮБ, Интерпол, Засгийн газрын бус байгууллагууд хэрэгжүүлэх ёстой болсон юм. Ер нь гэмт хэрэгтэй явуулах олон улсын хамтын ажиллагаа нь яг цагтаа эрх зүй, зохион байгуулалт, шинжлэх ухааны бэлэн хангамжийг шаарддаг нь олон талын учиртай байдаг.

1945 онд НҮБ байгуулагдаж улс хоорондын бүх чухал асуудлаарх олон улсын хамтын ажиллагааг хариуцах болжээ. Гэмт явдалтай хийх тэмцэл дэх улс хоорондын хамтын ажиллагааны асуудлыг гэмт явдлаас урьдчилан сэргийлэх болон эрхийн зөрчил гаргагчидтай харьцах шинжээчдийн хороог өөрийн бүтэцдээ 1950 онд буй болгож, НҮБ-ын гол байгууллага-эдийн засаг, нийгмийн зөвлөл /ЭЗНЗ/ шууд эрхлэх болгов. Дээрх хороо 1971 онд гэмт явдлаас урьдчилан сэргийлэх хороо, 1993 онд ихээхэн өндөр түвшингийн байгууллага болох гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ба эрүүгийн шүүх эрх мэдлийн комисс болон өөрчлөгдсөн юм. Энэ нь эдийн засаг нийгмийн зөвлөлд гэмт явдалтай хийх тэмцлийг үр дүнтэй болгох, мөн эрх зөрчигчидтэй хүнлэг харьцах чиглэлээр зөвлөж, санал оруулна. Түүний дээр Ерөнхий ассамблей энэ хороонд 5 жилд нэг удааа гэмт явдлаас урьдчилан сэргийлэх мөн эрүүгийн шүүх эрх мэдлийн холбогдолтой олон улсын дүрэм, зөвлөмж, стандарт боловсруулж НҮБ-ын конгрессд бэлтгэж өгөх үүргийг даалгасан байдаг. Одоогийн байдлаар 9 удаагийн Конгрессын хуралдаан эрх зүй, шинжлэх ухааны боломж бүхий байр сууринаас улс хоорондын хамтын ажиллагааны асуудлыг нэлээд амьдралтай авч үзсэн юм.

НҮБ-ын конгресс 1955 онд Женевт, дараа нь Их Британийн нэгдсэн вант улсын засгийн газрын урилгаар 1960 онд Лондон хотноо, гурав дахь нь Шведийн Засгийн газрын урилгаар Стокгольмд 1965 онд, 1970 онд Японд, 1975 онд Женевийн үндэстнүүдийн ордонд, 1980 онд Венесуэлд, 1985 онд Миланд, 1990 онд Куба, 1995 онд Египет улсад тус тус хуралджээ.

Анхдугаар Конгресс олон улсын эрх зүйн онц чухал бичиг баримтуудыг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, эрүүгийн шүүх эрх мэдлийн хэм хэмжээ, стандартыг хэрэглэх ажлыг нэгэн мөр болгоход

гол үүрэг гүйцэтгэв. Түүний ажлын асар олон жагсаалтаас дөнгөж хэдхэнийг дурдъя.

Хоригдолтой харьцах наад захын жишиг дүрэм, хууль хамгаалах байгууллагын зан үйлийн хууль, бүх хүмүүсийг эрүүдэн шүүх, бусад байдлаар хатуу харгис, хүнлэг бус, нэр хүндийг нь гутааж доромжлон харьцах, яллахаас хамгаалах тухай декларацийг боловсруулсан эдгээр бичиг баримт амьдралд хэрэгцээний бууршгүй шаардлагаар 1975, 1990 онуудад өргөжиж батлагдсан байна.

Энэ чиглэлээр Конгрессын хуралдаанууд дотроос 6, 9-р хуралдаанууд илүү их үр ашигтай байсан гэдэг юм. 6-р хуралдаанаар нийгмийн нөхцөлийг сайжруулах салбарын дэвшил, амьжиргааны чинсааны дээшлэлтээс юуны өмнө шалтгаацах, ялангуяа гэмт зан төлөвийн шинэ болон энгийн бус хэлбэрүүдийн тархах нөхцөл бүхий үеийн гэмт явдлаас урьдчилан сэргийлэх хэтийн төлөв, эрүүгийн шүүх цаазын тогтолцооны боломжийг сайшаах, үүний тулд гэмт явдалтай хийх тэмцлийн хэтийн төлөвийг хууль зүйн шалгууртайг эргэн харахыг тунхаглан сонордуулсан Каракасын декларацийг баталсан болно. Энэ үеэс конгресс гэмт явдлаас урьдчилан сэргийлэх хэтийн төлөв, засгийн эрх мэдлийг хууль бусаар авахаас урьдчилан сэргийлэх, насанд хүрээгүйчүүдтэй харьцах хууль зүй, шударга ёсны наад захын хэм хэмжээ, шүүгчийн хараат бус байдлыг хангахад барих зарчмууд, эрх зүйн мэдээлэл, мөн эрх зүйн мэдээллийг дэлгэрүүлэх зэрэгт холбогдох 20 орчим тогтоол батлав. 7-р конгресс гэмт явдал нь үндэстэн болон улс үндэстнүүд хоорондын хэмжээн дэх хойшлуулшгүй чухал асуудал болж буйг тодорхойлсон Миланы үйл ажиллагаа төлөвлөгөөг баталж чухамхүү гэмт явдал ард түмнүүдийн улс төр, эдийн засаг, нийгэм соёлын хөгжилтөд саад тогтор болж хүний эрх, үндсэн эрх чөлөө мөн түүнчлэн эрх тайван, тогтонги үе, аюулгүй байдлын аль алинд заналхийлж байна гэж үзжээ. Мөн энд гэмт явдлаас урьдчилан сэргийлэхэд дээд зэргээр анхаарч хоёр ба бусад орны хоорондох хамтын ажиллагааг идэвхижүүлэх, криминологи судалгаа шинжилгээг хөгжүүлэх, аллага, мансууруулах болистой тэмцэхэд онцгой анхаарал төвлөрүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд өргөн олны оролцоог бодитой хангаж өгөх асуудлуудыг засгийн газруудад зөвлөсөн баримт бичиг баталсан юм. Цааш нь уг конгресс нь насанд хүрээгүйчүүдийн хамрагдах бүх төрлийн хорих ялын талаар НҮБ-ын жижиг дүрэм /Бээжингийн дүрэм/ Засгийн эрх мэдлийг хууль бусаар авах болон гэмт хэргийн хохирогчийг мөрдөн шүүхтэй холбогдох үндсэн зарчмын деклараци; шүүхийн байгууллагуудын хараат бус байдлын үндсэн зарчмууд зэрэг 25 бичиг баримтыг

гаргажээ.8-р конгресс гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ба мөрдөх ажиллагаа; эрүүгийн шүүх мөрдөх ажиллагаан дахь улс төрийн бодлого; зохион байгуулалттай гэмт хэрэг; алан хядах гэмт ажиллагаатай хийх тэмцлийн үндэсний, мөн улс хоорондын үр ашигтай үйл ажиллагаа; гэмт явдлаас урьдчилан сэргийлэх болон шүүн мөрдөх ажил дахь НҮБ-ын баримтлах зарчим, хэм хэмжээ зэргийг хэлэлцжээ. Конгрессын энэ хуралдаан нь хамгийн олон буюу 35 тооны бичиг баримт баталсны дотроос насанд хүрээгүйчүүдийн гэмт явдлаас урьдчилан сэргийлэхэд НҮБ-ын баримтлах зарчмууд /Эр-Риядийн зарчмууд/; хот орчны гэмт явдлаас урьдчилан сэргийлэх, албан хядах үйл ажиллагаатай хийх тэмцэл; төрийн удирдлагын хүрээн дэх авилгал; хоригдогсодтой харьцах үндсэн зарчмууд; шорон, хорихыг удирдах салбар дахь улс хоорондын болон бүс хоорондын хамтын ажиллагаа зэргийг дурдаж болох байна. 9-р конгресс. Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх болон эрүүгийн шүүх эрх мэдэл; үндэстний ба улс хоорондын эдийн засгийн болон зохион байгуулалттай гэмт явдалтай тэмцэх арга хэмжээнүүд; цагдаа мөн хууль хамгаалах бусад байгууллага болох прокурор, шүүх, засан хүмүүжүүлэх байгууллагуудын ажлыг удирдах боловсронгуй болгох; гэмт явдлыг урьдчилан сэргийлэх хүрээн дэх хэтийн төлөв гэх 4 асуудлыг хэлэлцсэн болно.

Конгресс энэ хуралдаанаараа эрх зүйн зөрчил гаргагчидтай харилцах ба гэмт явдлаас урьдчилан сэргийлэх зөвлөмж, зохих байгууллагатай гэмт хэрэгтэй хийх тэмцлийн талаарх конвенцийг батлах тухай санал, гэмт хэрэг үйлдсэн болон гэмт хэргийн хохирогч болох хүүхдүүдийн тухай, эмэгтэйчүүд хүчирхийлэлд өртөх явдлын тухай, гэмт явдлаас урьдчилан сэргийлэх болон нийгмийн аюулгүй байдлыг хангахад чиглүүлсэн галт зэвсгийн эргэлтийг зохицуулах тухай зэрэг 11 төрөл бичиг баримт баталсан ажээ.

Ер нь конгрессийн шийдвэр нь зөвлөх шинж бүхий томоохон арга хэмжээ байдгийн дээр энэ байгууллага чухал асуудлуудыг дэлхий дахины криминологийн нөхцөл байдалтай холбогдуулан цаг тухайд нь анхаарч шинэ шийдвэр нэмж гаргадаг. НҮБ-ын эдийн засаг нийгмийн зөвлөлд 1961 оны дундуурх мансууруулах бодисын тухай конвенцийн үндсэнд буй болсон мансууруулах бодисын чиглэлээрх комисс, мансууруулах бодисыг хууль бусаар худалдах, тэмцэх салбар комисс, олон улсын хэмжээн дэх алан хядах үйл ажиллагааны чиглэлээрх тусгай хороо, мансууруулах бодист хяналт тавих олон улсын зөвлөл эд бүгд үйл ажиллагаагаа явуулна. Эдгээр хороо, комиссууд нь НҮБ байгуулсан бусад албадтай зэрэгцэн мансууруулах бодисын болон үндэстэн хооронд дамжсан бусад гэмт явдлуудтай

холбоо бүхий улс төрийн хамтын ажиллагааны асуудлыг шийдэж байна. Олон улсын хамтын ажиллагааны уламжлалт хэлбэрүүд нь хүндрэлтэй болон зайлшгүй чухал асуудлаарх олон улсын бага хуралдаан, мөн бусад арга хэмжээтэй сайтар хосолж байгаа болно. Одоо тэдгээрийн нэг болох зохион байгуулалттай гэмт явдалд анхаарлаа хандуулж үзье. Сүүлийн 20 гаруй жил энэ асуудал яригдаж байна. Олон улс хоорондын бизнесийн хэлбэрт энэ явдал нь ерийн нэг гэмт зан байдлын хэлбэрт бүр илүү эмзэглэн учрыг агуулдаг талаар анх удаа 5-р конгресс дээр яригдсан юм байна. Үүний дараа YI конгресс хууль хүрэлцэх тэр хэмжээний гадуур буюу "хуулийн цоорхой" болж байгаа зохион байгуулалттай гэмт хэрэгтнүүдийн учир шалтгаанаар бий болж буй түгшүүрт мөн л анхаарлаа хандуулсан юм. 7-р конгресс зохион байгуулалттай гэмт явдалд янз бүрийн улс орнуудын хууль тогтоомж дахь дутагдлууд ашиглагдаж буй асуудлыг хэлэлцэж байлаа.

VIII конгресс зохион байгуулалттай гэмт явдлаас урьдчилан сэргийлэх болон түүнтэй хийх тэмцэлд удирдлага болгох зарчмуудыг баталсан юм. Эдгээр нь бүгд ерөнхий ассамблейгаар дэмжигдэн, зохион байгуулалттай гэмт явдалтай хийх тэмцлийн олон улсын бичиг баримт болон батлагдсан байна. Энэ асуудлын янз бүрийн төлвүүдийг НҮБ, Интерпол, Засгийн газрын бус байгууллагууд 1991 онд Чехословакийн зөвлөлгөөнөөр, мөн Суздалын /Орос/ олон улсын бага хурлаар, Италид 1995 онд "Мафийн эсрэг юу хийх ёстой вэ?" гэсэн олон улсын бага хурлаар тус тус хэлэлцэж байжээ. 1995 онд Неополь хотноо салбаруудыг оролцуулсан хэмжээнд хийсэн дэлхий нийтийн бага хурал нь дэлхийн янз бүрийн бүс нутаг дахь зохион байгуулалтааь гэмт явдлын аюулын тухай асуудал, зохион байгуулалттай гэмт явдалтай явуулах тэмцлийн хэрэгжилтэд янз бүрийн орнуудын хууль тогтоомжийн адил тэнцүү байдлын тухай, зохион байгуулалттай гэмт явдалтай хийх тэмцлийн хамтын ажиллагааны үр ашигтай хэлбэрийн асуудал, зохион байгуулалттай гэмт явдлыг урьдчилан сэргийлэх болон тухайн конвенцийг чиглэл зорилготой батлах зарчмын тухай гэх мэтчилэнгээр авч хэлэлцсэн нь онцгой ач холбогдолтой болсон юм.

Эдгээртэй адил төсөөтэй хэмжээнд мансууруулах бодис, зэвсгийг хууль бусаар дэлгэрүүлэх, улс хоорондын авилгал, үндэстэн дамжсан бусад гэмт явдлууд, мөн үүний дээр экологийн аюулгүй байдлын хүрээн дэх хамтын ажиллагаа зэрэг онцгой тулгамдсан ажлууд маш хурдацтай гарч ирж байгаа юм. НҮБ-ын дэргэд зөвлөмжлөх эрхтэй ажиллах засгийн газрын бус байгууллагууд гэмт

явдлын эсрэг явуулах хамтын ажиллагаанд чухал бөгөөд ээдрээтэй асуудлуудыг шийдэлцдэг. Эдгээрт олон улсын эрүүгийн эрхийн холбоо /ОУЭЭХ/ Олон улсын криминологийн нийгэмлэг /ОУКН/, олон улсын нийгэм хамгааллын байгууллага /ОУНХБ/, олон улсын эрүүгийн болон пенитенциари /Хорих байгууллага/-ын фонд /ОУЭХБФ/ болно. Тэдгээрийн ажиллагааг олон улсын зохицуулах хороо /ОУЗХ/ буюу ердийн нэрлэдгээр "Дөрвийн хороо" чухамдаа 1960 оноос зохицуулж байгаа бөгөөд энэ хорооны ажиллагаа 1982 оноос хуулийн хүчин чадлаа бүрнээ олсон юм. Гэмт явдалтай тэмцэх хүрээний НҮБ, олон улсын улс төрийн бодлогод дөрвийн хорооны хийх үйл ажиллагаа үр дүнтэй нөлөөлж байгаа юм. Энэ хорооны үйл ажиллагаа юуны өмнө НҮБ-ын хуралдаанд бэлтгэх олон улсын нийгэмлэгийн хангаж хэрэгжүүлэх асуудлын төлөвлөгөөтэй холбоотойгоор илэрдэг юм. Тус хороо эдийн засаг нийгмийн зөвлөлд /ЭЗНЗ/ зөвлөмжлөх эрхтэй байх бөгөөд албан бус ярилцлага Коллоквиумд бэлтгэх нийгэмлэгийн ажлыг зохицуулах, НҮБ-тай хамтран ажиллах олон улсын байгууллагуудыг урьж оролцуулах, мансууруулах бодисыг хууль бусаар ашиглахтай тэмцэх, НҮБ-ын фондод зөвлөгөө өгөх гэмт явдлын хохирол судлалын бүх дэлхийн нийгэмлэг, мөн сэтгэцийн эрүүл мэндийн бүх дэлхийн холбоотой хамтран ажиллах ажиллагааг хэрэгжүүлдэг.

Ер нь олон улсын зохицуулах хороогоор гэмт явдалтай тэмцэх болон зөрчил гаргагчидтай харьцах үйл явц, мөн олон улсын хамтын ажиллагааг дэлхийн хэмжээнд гаргахтай холбоотой олон аспект-төлөвүүд шүүн хэлэлцэгдэж нягтлагддагийн дээр ОУЭЭХ, ОУКН, ОУЭХБФ-уудын ажиллагааг бүрнээ зохицуулж байна. Олон улсын эрүүгийн эрхийн холбоо нь /ОУЭЭХ/ 1924 онд үндэслэгдсэн бөгөөд гэмт явдал, тэдгээрийн шалтгаан, гэмт явдалтай хийх тэмцлийн хэрэгслийг судлах, эрүү-эрх зүйн харьцуулсан судалгаа эрхлэх, 5 жил тутамд эрүүгийн эрхийн асуудлаар хийх олон улсын хуралдааныг явуулах ажлуудынхаа зэрэгцээ НҮБ, ЮНЕСКО болон олон улсын бусад байгууллагад зөвлөгөө өгдөг юм. Энэ холбооны гаргадаг "Олон улсын эрүүгийн эрхийн тойм" сэтгүүлд үндэстний болон улс хоорондын эрүүгийн эрхийн тулгамдсан асуудлууд нийтлэгдэнэ. Мөн энэ холбооны ивээл дор эрүүгийн эрхийн шинжлэх ухааны олон улсын дээд институт ажилладаг.

Олон улсын криминологчдын нийгэмлэг /ОУКН/ 1934 онд үндэслэгдсэнээсээ хойш гэмт явдалтай тэмцэх хамтын ажиллагааг хангахад бүрнээ чиглэгдэж ирсэн юм. Энэ нь үндэстний институтууд болон криминологийн мэргэжилтнүүдийг нэгтгэдгийн дээр мөн л ОУЭЭХ-ны адилаар ЭЗНЗ, НҮБ, ЮНЕСКО-д зөвлөгөө өгнө. Бас бусад

олон улсын байгууллагуудтай хамтран ажиллана.

ОУЗН нь олон улсын хэмжээн дэх гэмт явдлын шалтгааны судалж криминологийн хуралдаан, семинар, албан бус ярилцлагыг зохион байгуулан, тэдгээрийн бичиг баримтуудыг нийтэлж криминологийн үндэсний институт байгууллагуудтай хамтарсан ажиллагаа явуулж улмаар криминологийн шинжлэх ухааны урамшуулах шан хөлсийг тогтоож байдаг юм.

Олон улсын криминологийн Үийгэмлэг 10 гаруй удаагийн хуралдаан зохион явуулсны нэг дэх нь 1932 онд Ром хотод, хоёр дахь нь криминологийг салбар шинжлэх ухаан болгохыг хүлээн зөвшөөрөх асуудлаа 1950 онд Парис хотноо хуралдсан болно. 1955 онд дадлагажсан гэмт явдлын талаар Лондонд, 1960 онд сэтгэцийн өвчний зан төлвөөр Гагад, 1965 онд криминологийн шинжлэх ухааны хэсэг дэх социологийн болон биологийн харьцуулсан шинжилгээ судалгаагаар Монреальд, 1970 онд криминологийн арга судлалын шинжилгээний асуудлаар Мадридид, 1973 онд криминологийн чиглэл хандлагыг хэлэлцэх асуудлаар Белградд, 1978 онд Чөлөөт хөтөлбөрөөр Лиссабонд, 1983 онд криминологи дахь эмгэг болон социологийн чиглэлийн харьцааны улс төр судлал, социологи, криминологчдын харилцаа холбоонд анхаарал төвлөрүүлэх асуудлаар Венад, 1988 онд гэмт явдлын байдал, түүнтэй хийх тэмцлийн хэтийн төлөв, криминологийн ирээдүйн асуудлаар Гамбургт, 1993 онд Төв болон Дорнод Европ дахь гэмт явдал, түүний нийгэм улс төрийн өөрчлөлтийн асуудал гэх зэргээр удаа дараалан эмзэг тулгамдсан асуудлуудыг хэлэлцэж байсан байна. ОУКН нь янз бүрийн улс орнуудад криминологийн курс зохион байгуулсан, түүний анхных нь 1952 онд Парис хотноо болсон юм. Энэ чиглэлийн ажиллагаа 50 орчим удаа дэлхийн өнцөг булан бүрд зохиогдлоо. Эдгээртэй адил ажлуудыг өөр өөрийн чиглэлээр ОУНХН, ОУЭХБФ мөн л явуулдаг юм.

Вена хотноо 1923 онд байгуулагдсан эрүүгийн цагдаагийн олон улсын байгууллага Интерпол нь онцгой байр суурь эзэлдэг болно. Энэ байгууллага дэлхийн II дайны дараа 1946 онд Парис хотноо сэргээн байгуулагдаж, 1989 онд төв нь Леон хотноо шилжиж байршсан юм. Монгол Улсын 1991 онд Интерполын гишүүн орон болсон бөгөөд ер нь энэ байгууллагад 178 улс нэгдэн орсон байдаг. Дээд байгууллага нь ерөнхий чуулган, хуралдаан нь нэг удаа болно. Гүйцэтгэх хороо нь бүс нутгийн төлөөлөгчөөс бүрдэнэ. Байнгын ажиллагаатай нарийн бичгийн дарга нарын газар ажиллана. Бас шинжлэх ухааны бичиг баримтууд боловсруулах зорилготой зөвлөгчдийн институттэй. Интерпол улс орон бүрд өөрийн

товчоотойгоороо бусад олон улсын байгууллагуудаас ялгагддаг болно. Тухайн орнууд үйлчилж буй хуулийнхаа хүрээнд эрүүгийн гэмт хэргээс сэргийлж чадах байгууллагыг бий болгож ажиллахад нь дүрэмд заасны дагуу тусалж хамтын ажиллагааг хөтлөн явуулна.

Ер нь хамтын ажиллагааны үндсэн хэлбэр нь үндэсний товчоодоос тодорхой эрүүгийн хэргийн мэдээлэл авах, дамжуулах, судалгаа хийх, мөн тэдгээр товчоодод шилжүүлэх явдал байдаг. Үндэсний товчоод өөрийн орны хууль хамгаалах байгууллагатай, олон улсын хэмжээнд бусад орны товчоодтой болон Интерполын ерөнхий нарийн бичгийн дарга нарын газартай байнгын холбоотой байна. Эдгээрээс үзвэл олон улсын гэмт явдалтай тэмцдэг бөгөөд гол анхаарлаа олон улсын конвенцид заагдсан гэмт явдал, мансууруулах бодисын худалдаа, бизнес, зохион байгуулалттай улс хоорондын гэмт явдалд төвлөрүүлж байна.

Ерөнхий нарийн бичгийн дарга нарын газар олон улсын гэмт хэрэгтний тоо бүртгэл, холбогдох бичиг баримтуудыг нягтлан тогтоох, дүн шинжилгээ болон шинжлэн судлах ажил явуулахын дээр олон улсын болоод үндэстний хууль тогтоомжийг боловсронгуй болгох саналуудыг төлөвлөдөг байна. Тодорхой жишээ татахад Интерпол нь НҮБ болон олон улсын иргэний агаарын тээврийн байгууллагатай, агаарын хөлгийн гэмт хэрэгтнүүд барьцаалах буюу хулгайлах үеийн аюулгүй байдлын арга хэмжээнүүдийг хамтран боловсруулна. Яг энэ чиглэлээр дээр дурдсан Гаага, Монреалийн иргэний агаарын тээврийн конвенцууд боловсруулагдсан байдаг бөгөөд түүнд агаарт болон газар дахь урьдчилан анхаарсан систем тусгагдсан байдаг байна. Чухамдаа энэ конвенц хэрэгжсэнээр онгоц барьцаалалт 2 дахин буурсан гэдэг юм. НҮБ, олон улсын засгийн газар хоорондын болон засгийн газрын бус байгууллагууд гэмт явдалтай тэмцэх, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн олон улсын хамтын ажиллагааг үр бүтээлт хандлагаар хэрэгжүүлэх зохион байгуулахад чухалчлан анхаардаг болно.

Энэ талаар зохицуулалтын бичиг баримт, криминологийн болон эрүүгийн эрхийн тоо сэлт, эрүүгийн улс төрийн бодлогын судалгаа шинжилгээг орон бүхэнд үндэсний болон улс хоорондын гэмт явдлыг үр дүнтэй хязгаарлан барихад чиглүүлэн төвлөрүүлдэг байна.

Гэмт явдалтай тэмцэх олон улсын тэмцлийн хамтын ажиллагааг энэ хүрээнд ойлгож болох юм



ХЦДС-ийн эрх зүйн тэнхимийн
багш Л.Сандагсүрэн